

Монгол улс дах сонгон шалгаруулалт

● Сонгон шалгаруулалт бол үйл ажиллагаа

Монгол дах сонгон шалгаруулалтийн үндсэн зарчим бол гадаад хүнд ч, монгол хүнд ч адилхан дараах удирдамжаар үйлчилнэ.

1. Та үнэхээр хэн нэгнийг хөслөх хэрэгтэй юу гэдгээ өөрөөсөө асуу. Та зохион байгуулалтаа өөрчлөх эсвэл үйл ажиллагаа, дүрэм журмаа уян хатан болгож чадах эсэх.
2. Хамтын ажиллагаан дах хоёр талын үүрэг, үр дүнгийн гүйцэтгэлээ нарийвчлан тодорхойлж бич.
3. Хүн тус бүр дээр туршлага, чадвар ба өндөр бүтээмжтэй ажиллахад бусад чухал шинж чанарыг нарийвчлан гаргах (Хэт санаа тавихаас болгоомжил)
4. Зар сурталчилгааг бэлтгэн гаргах
5. Урьдчилан асуултаа төлөвлө, оновчтой хариулт нь ямар байх вэ гэдгээ тунгаа
6. Өргөдлийг няхуур шалга
7. Таны шалгуурт таарах хүмүүсээс л ярилцлага ав
8. Шалгууртаа хоёр дах саналыг авахын тулд, бусад менежерээ татан оролцуул
9. Тодорхойлолт болон диплом гэрчилгээг нэг нэгдгүй шалга
10. Танд Монгол улсын хуулиар баталгаажигдсан шаардлагад тохирох хөдөлмөрийн гэрээ байгаа гэдгээ баттай ойлгуулах
11. Гурван сарын туршилтын хугацаатай гэрээ байгуулах тухайгаа ойлгуулах

Шинэхэн төгсөгч болон төгсөх ангийн оюутан хөлслөх үед анхаарах зүйл

Хэрэв та монгол иргэнийг худалдаа, үйлчилгээний газар болон захиргааны албан тушаалд хөлслөн ажиллуулах гэж байгаа бол, жирийн албан тушаалд шинэхэн төгсөгч болон төгсөх ангийн оюутныг илүү харж үзэхийг зөвлөж байна. Залуу төгсөгчийн хувьд ажлын туршлага дутмаг хэдий ч идэвхи гарган ажиллах, богино хугацаанд дадлагажих чадвартай байдаг. Компаниудын ихэнхи ажлын байр нь төгс, өндөр түвшний мэдлэг туршлага шаардагдах ажил байдаггүй. Ихэнх туршлагатай ажилчид ажлын муу зуршилтайгаас гадна, зарим тохиолдолд ичгүүргүй хандлага гаргадаг. Мэдээж, тодорхой удирдах болон мэргэжилтний албан тушаалд илүү туршлагатай хүмүүс хэрэгтэй. Удирдах албан тушаалтныг хөлслөхөд, ялангуяа сонгон шалгаруулалт өндөр эрсдэлтэйгээс гадна, нягт нямбай хандах шаардлага гарна.

Гадаадын иргэнийг хөлслөх

Монгол дах гадаадын иргэнийг хөлслөхөд урьдчилан тооцоогүй зүйл гардаг. Монголд ирээд удаагүй, ажил хайж байгаа гадаадын иргэд бол тогтвор суурьшилтай ажиллах сонирхол багатай. Тэд аливаа ажилд чин сэтгэлээсээ хандах хандлагаас илүүтэй, эдийн засгийн сонирхол нь давамгайлж байдаг. Тэд илүү боломжтой ажил олдвол эргэлзээгүй орхин оддог. Жинхэнэ мэргэжилтнүүд бол монголд ирэхээсээ өмнө ажлаа төлөвлөсөн байдаг. Мэдээж,

монголд сайн ажилтай гадаадын иргэд бол, мэргэжлээ дээшлүүлэх, эдийн засгийн асуудлаас болж хоёр дах боломжийг хайж байдаг. Энэ бүлгийн хүмүүс бол чадвартай ба та тэдний өрсөлдөх чадвар, ажлын байдал төлвийн тухай хамааралтай мэдээллийг сүлжээгээр олж авах боломжтой.

Буруу эдийн засаг

Сонгон шалгаруулах ажиллагаанд хоёр буруу эдийн засаг байдаг. Өрсөлдөх чадваргүй цалин бол өрсөлдөгчийн тоог хязгаарласан сонголт болохоос гадна, чадвартай сайн ажилтан бага цалинтай ажилд ирэх боловч, та урт хугацааны турш үлдэнэ гэж найдах хэрэггүй. Хэрэв та, таны санал болгосон цалинд сэтгэл хангалуун байх боловч, үндсэн ур чадвар тийм ч сайнгүй хэн нэгнийг хөлсөлсөн бол, та урт хугацааны турш өндөр хөлс төлөх болно.

Хэтэрхий бага хугацааны хөрөнгө оруулалт ба сонгон шалгаруулах ажиллагаанд зарцуулах зардал бол эдийн засгийн нөгөө буруу ажиллагаа юм. Хэрэв та үл хөдлөх хөрөнгөө зарлахгүй бол, таны ажлын байрны нэр дэвшигчийн тоо хязгаарлагдана. Нэр дэвшигчийн ядруухан сонголт нь, олон компанийг муу хүмүүсийг хөлслөхөд хүргэдэг. Хэрэв та сонгон шалгаруулах ажиллагаанд цаг, зардал мөнгө зарахгүй бол танд алдаа хийх маш өндөр боломж гарна.

Цаг үеийн шаардлага

Хэрэв хэн нэгэн компанийг орхивол, зарим менежер шоконд ордог. Яаравчлан хэн нэгнийг олно гэдэг бол том алдаа юм. Таны чадна гэж сонгосон хүн халагдчихлаа, тийм хүн энэ албан тушаалд тохиромжгүй.

Томоохон байгууллагууд бол, сул орон тооны ажлын байрыг дүүргэхэд бэлэн байхаар дадлагажигч хүмүүс нэр дэвшигчийг цуглуулахын тулд байнгын сонгон шалгаруулах компани ажил зохион байгуулах хэрэгтэй. Хэрэв танд хүчирхэг ажилчид байгаа бол, хүмүүс ажлын байраа орхих үед түүнийг орлох чадвар бүхий найдвартай багтай байх хэрэгтэй.

Жижиг байгуулагуудын хувьд, зөв хүнээ сонгон олж авахад чармайлт гаргах хэрэгтэй. Монголд удирдах эсвэл мэргэжилтний албан тушаалд нэр дэвшигчийн тоо хягаартай байгаа тул, та сонгон шалгаруулалтаа урт хугацаанд явуулаарай. Сайн боловсруулсан бодлого нь буруу сонголт хийхээс сэргийлнэ.

Орон нутгийн сонингууд

Монголд, ажилчдад хууль ёсны арга хэмжээгээр хандах нь элбэг. Гэрээ, ажил, ажлын тодорхойлолт ба сахилгын үйлдэл нь доголдолтой компаниуд ихэвчлэн заргаа алддаг.

Соёлын ялгаа

Хэрэв та, гадаад иргэн хөлслөх гэж байгаа монгол хүн эсвэл монгол хүн хөлслөх гэж байгаа гадаад иргэн бол, нэр дэвшигчийг сонгоход аюултай. Энэ тохиолдолд сөрөг онцлогийг илрүүлэхэд их хэцүү. Яагаад гэвэл, сонгогчид өөрийн орны хэн нэгэнтэй ярилцлага хийж байгаа үед олж хардаг шигээ дүгнэж, үйл хөдлөл дохиог мэдэрч чаддаггүй. Эцсийн шийдвэр

гаргахаас өмнө, нэр дэвшигчийн хэл, соёлыг мэддэг хэн нэгний дэмжлэгийг авах нь зүйтэй.

Сонгон шалгаруулах агентлагууд

Сонгон шалгаруулах агентлагууд бол монголд харьцангуй шинэ зүйл юм. Хэрэв та сонгон шалгаруулах агентлаг ашиглах гэж байгаа бол та дараах зүйлийг санах хэрэгтэй. Сонгон шалгаруулах агентлагууд бол хүмүүсийг олох тал дээр, тэдэнд зөвөөр үнэлгээ өгөхөөс илүү байж чадна. Хэрэв агентлаг үнэлгээ өгөх чадвартай гэдгээ зарласан тохиолдолд ч, сонгон шалгаруулах агентлагийн үнэлгээн дээр хэзээ ч бүү татгалз. Хэрэв тэд сонины зарлалын дагуу сонгон шалгаруулах агентлагийн шалгаруулалтанд ороод тэнцэн ирж байгаа бол, тэдгээр нэр дэвшигчдийг хүлээж ав. Сонгон шалгаруулах агентлаг бол борлуулагчид юм. Та тэдний барааг (энэ тохиолдолд хүн) худалдаж авах үед, тэд өөрсдийн захиалгаараа орлого олно. Борлуулагчид бол гол төлөв, барааныхаа тэнцвэртэй үнэлгээг танд өгдөг. Тэд аль болох сайн тал руу чиглүүлэхийг зорьдог.

Та гэрээ хийх үедээ маш болгоомжтой бай. Сайн гэрээ бол юунаас ч чухал. Хэрэв та тэднээс түрүүлж нэр дэвшигчээ олбол тэдэнд төлбөр төлөхгүй. Зөвлөж хэлэхэд, сонгон шалгаруулалтын төлбөрийг урьдчилан төлөх хэрэггүй. Хэрэв төлчихвөл сонгон шалгаруулах агентлаг хайнга хандах талтай.

Хэрэв хилийн чанадаас гадаадын иргэн хөлслөх гэж байгаа бол, та магадгүй мэргэжлийн сонгон шалгаруулах байгууллагын тусламжыг хүсэх байх. Гэрээ байгуулахаас өмнө, тэр байгууллагыг сайтар няхуур шалга.

Шаардлага хангаагүй найз нөхөд, хамаатан саднаа хөлслөх дарамтаас зайлсхийх нь

Олонхи хүний нөөцийн мэргэжилтнүүд, найз нөхөд хамаатан садныг нь хөлслөөгүйн төлөө, хүнд цохилттой учрах болов уу. Өмч хөрөнгийн хамааралтай, зөв зохистой туршлагатай хамаатан садан бол бүлгийн үнэнч, сайн гишүүн байж чадна. Хэдий тийм ч, хамаатан садныг удирдахад сахилга бат хэрэгтэй. Менежер бол тэдэнд тэгш хандах ёстой.

Сайн найзууд бол магадгүй сайн ажилладаг ч, хэрэв тэд таны төлөө ажилладаг бол эцэст нь та найзуудаа алдах явдал гарч магадгүй.

Хэрэв дээд албан тушаалтныхаа найз нөхөд, хамаатан садныг хөлсөлбөл, менежерүүдэд дарамт болох нь ховор тохиолдол биш. Хэрэв чамайг, иймэрхүү хүн түйвээж, дарамтлаж эсвэл ажил хийхэд шаардлага хангахгүй байгаа бол, та чадах чинээгээрээ тэвч.

Хамаатан саднаа хөлслөх бол монголын гол асуудал болоод байна. Бизнес болон компаний ажилчид нь хоорондоо садан төрлийн холбоогүй бол жинхэнэ өрсөлдөөн.